

1. Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээтэй болон зөвшөөрөл хүсэх мэдүүлгээ өгсөн хүн

(1) Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээгээ авсан иргэдийн тухайд

Жирийн нөхцөлд 3 сарын хүчинтэй хугацаатай байдаг боловч, тусгай тохиолдол болгон дараах аргачлалаар тооцно.

○ 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс 2022 оны 4 сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд олгосон оршин суух зөвшөөрлийн гэрчилгээг 2022 оны 10 сарын 31-ний өдрийг хүртэл хүчинтэйд тооцно.

○ 2022 оны 5 сарын 1-ний өдрөөс 2022 оны 7 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд олгосон оршин суух зөвшөөрлийн гэрчилгээг олгосон өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд хүчинтэйд тооцно.

* Мөн, өмнөх мэдүүлгийн агуулгаас өөрчлөгдөөгүй ба 2023 оны 1 сарын 31-ний өдөр гэхэд оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах өргөдөл гаргах тохиолдолд (1) Өмнө нь олгогдсон оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (эх хувь эсвэл хуулбар) болон (2) Хүлээж авах байгууллагын гаргасан учир шалтгааны тайлбар бичгийг бүрдүүлснээр шинэ оршин суух зөвшөөрлийн гэрчилгээг шуурхай олгох болно. Дэлгэрэнгүйг [эндээс](#) харна уу.

(2) Оршин суух зөвшөөрөл хүсэх мэдүүлгээ өгсөн иргэдийн тухайд

Одоо оршин суух зөвшөөрөл хүсэх мэдүүлгээ өгсөн иргэдийн тухайд, үйл ажиллагаа эрхлэх хугацааг өөрчлөх тохиолдолд, **зөвхөн хүлээж авах байгууллагын учир шалтгааны тайлбар бичгийг** үндэслэн шалгана.

2. Оршин суух зөвшөөрөл хүсэх мэдүүлгээ өгсөн хугацаандаа дахин хилээр нэвтрэн орох зөвшөөрөл авч, Япон улсаас гарсан хүн

[Анхаар] Үүнд 2022 оны 10-р сарын 11-ний өдрөөс хойш хүсэлт гаргасан тохиолдлыг тооцохгүй.

Хилээр дахин нэвтрэх зөвшөөрөл (дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл орно) авч, Япон улсаас гарсан гадаадын иргэн хилээр гарахаас өмнө оршин суух статусаа өөрчлөх, оршин суух хугацааг сунгах зөвшөөрөл хүссэн мэдүүлэг гаргасан, түүнчлэн байнгын оршин суугчийн зөвшөөрөл авах өргөдөл өгсөн байх хугацаанд COVID-19 халдварын тархалтаас болж хилээр дахин орж ирэхэд бэрхшээлтэй болсон тохиолдолд, **Япон улсад амьдардаг хамаатан садан, хүлээн авагч байгууллагын ажилтан гэх мэт хүн өргөдөл гаргагчийг төлөөлөн оршин суух үнэмлэхийг хүлээн авахыг зөвшөөрөх бөгөөд, Япон улсаас гарсан хүн хилээр дахин нэвтрэн орох зөвшөөрлөө үндэслэн гаалийн мэдүүлэг өгөх боломжтой.**

3. Хилээр дахин орох зөвшөөрөлтэйгээр хилээр гарсан байх хугацаанд хилээр нэвтрэн орох хүчинтэй хугацаа нь хэтэрсэн хүн г.м

[Анхаар] Энэ нь 2023 оны 4-р сарын 30-ны өдөр хүртэл хүчинтэй. ✳ Дэлгэрэнгүйг тус бүрийн холбоосоос шалгана уу.

(1) Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах шаардлагагүй иргэн (“байнгын оршин суугч” гэх мэт)

Зорчиж буй газрынхаа консулын газарт хүсэлт гаргана уу.

✳ “байнгын оршин суугч” хүн бол дэлгэрэнгүйг [эндээс](#) харна уу.

✳ “япон улсад цагаачлагч (заалтаас гадуур)” болон “тусгай үйл ажиллагаа” (заалтаас гадуур)-ний визтэй хүн [эндээс](#) дэлгэрэнгүй харна уу.

(2) Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах шаардлагатай хүн (оюутан, ур чадварын дадлагажигч, техник хүмүүнлэг олон улсын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл г.м)

Япон улсад дунд болон урт хугацаагаар оршин суугч (гадаад оюутан, ур чадварын дадлагажигч зэрэг) ангилалаар оршин сууж байсан хүн хилээр дахин нэвтрэх зөвшөөрөл авч Япон улсын хилээр гарсны дараа COVID-19 халдвараас шалтгаалан хилээр дахин орж ирэхэд бэрхшээлтэй болсноос хүчинтэй хугацаа дууссан тохиолдол зэргээс үүдэн, оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ дахин авах хүсэлт гаргах хүний хувьд, **өргөдөл болон хүлээн авах байгууллагын учир шалтгааны тайлбар бичгийг** үндэслэн шийдвэрлэнэ.

✳Дэлгэрэнгүйг [эндээс](#) харна уу.

(3) “Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн No.2” статусаар оршин сууж байсан хүн

(2) -с “Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн **No.1**” статусаар өмнөх ажилтай дүйцэхүйц оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах өргөдөл гаргана уу.

“Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн No.1”-н зөвшөөрөл авах боловч, хилээр нэвтрэн орох үед япон улсын гааль дээр “Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн No.2” болгон шинээр мэдүүлэх боломжтой.)